



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/9/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Г.Ганчимэг

Утас: 88268424

Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	8
2.8.2 Авлага	8
2.8.3 Бараа материал	9
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр.....	10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	14
2.12. Шилэн дансны мэдээлэл	14
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
1. Менежментийн захидал	16
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	18
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	19
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	22
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	24
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	25
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.03.25 № *1/375*
танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.ХАТАНБААТАР ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

• 005020312

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баян-Овоо сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ж.Хатанбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 10-ноос 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэв.

Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 20 -ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.-

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баян-Овоо сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баян-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	2	4	-	2	-
	Дүн	2	4	-	2	-

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баян-Овоо сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг аудитор гүйцэтгэлээ.

Баян-Овоо сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллага аудитад хамрагдсан байна. Үүнээс:

№	Байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр	Аудитад хийсэн байгууллага нэр
1	ЗДТГ	Хязгаарлалттай	
2	Эрүүл мэндийн төв	Зөрчилгүй	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
3	Ерөнхий боловсролын сургууль	зөрчилгүй	Глобал капитал аудит
4	Цэцэрлэг	Зөрчилгүй	Глобал капитал аудит
5	ИТХ	Түүвэрт хамрагдсан	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
6	Соёлын төв		
7	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар
8	Сум хөгжүүлэх сан		

Баян-овоо сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн дүгнэлтэд нөлөөлсөн гол зөрчил:

- Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн.

Тайлант онд 37277,0 мянган төгрөгийн өвс тэжээлийг анхан шатны баримтгүй зарцуулж, 30235,0 мянган төгрөгийн өвс тэжээлийн борлуулалтын орлого тодорхойгүй санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, гэсэн заалтууд зөрчсөн байна

Дээрх алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байсан тул санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ТТЗ-чийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар акт тогтоогоогүй, албан шаардлага өгөгдөөгүй.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

БНА-2020/9/СТА-ТТЗ

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд Ерөнхий боловсролын сургуулийн НДШ-ийг өглөгийг санхүүгийн тайланд дутуу тусгасан тул санхүүгийн тайланд залруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчил

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 267.45 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Төсвийн шууд захирагчийн тайланд илэрсэн алдаа, зөрчил /сая.төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс					
		Тоо	Дүн	Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ИТХ								
2	ЗДТГ	9	199.55	6	129.1	1	5.7	2	64.75
3	Ерөнхий боловсролын сургууль	1	0.3	1	0.3				
4	Цэцэрлэг								
5	Эрүүл мэндийн төв	3	3.7	2	2.7	1	1.0		
6	Соёлын төв								
7	Сум хөгжүүлэх сан	1	63.9			1	63.9		
8	Орон нутаг хөгжүүлэх сан								
	ДҮН	14	267.45	9	132.1	3	70.6	2	64.75

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 89404.5 мянга, эцсийн үлдэгдэл 36603.0 мянган төгрөг болж -52801.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Эцсийн үлдэгдлийн эзлэх хувь
Орон нутгийн ерөнхий орлого	338.7	36593.3	36254.6	99.97
ОНХС	5044.3	8.6	-5035.7	0.027
Сум хөгжүүлэх сан	84021.5	1.1	-84020.4	0.003
Дүн	89404.5	36603.0	-52801.5	100

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 36603.0 мянган төгрөг нь дээрх төрийн сангийн харилцах дансанд байршиж байна. Үүнээс Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 36593.3 мянган төгрөгийн үлдэгдлээс 5270.9 мянган төгрөг нь оны эцэст төсөвт байгууллагуудад орон нутгийн орлогоос санхүүжүүлсэн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн, 31322.4 мянган төгрөг нь урьд оны зарцуулаагүй үлдэгдэл болон тайлант оны татварын орлогоос төвлөрсөн орлого байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 99222.3 мянга, эцсийн үлдэгдэл 201411.7 мянга төгрөг олж 102189.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	307.6	2994.5	2686.9
Байгууллагаас авах авлага	1652.0	1609.0	-43.0
Хувь хүмүүсээс авах авлага	97262.7	196808.2	99545.5
Дүн	99222.3	201411.7	102189.4

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оноос 102189.4 мянган төгрөгөөр өссөний гол шалтгаан нь орон нутгийн хөгжлийн сангийн 7900.0 мянга, сум хөгжүүлэх сангаас зээл олгосноос авлага 91645.4 мянга, ерөнхий боловсролын сургууль 2140.0 төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

2.8.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 79009.9 мянга, эцсийн үлдэгдэл 96746.8 мянган төгрөг болж, 17736.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	1725.3	14667.7	12942.4
Бичиг хэргийн материал	3751.8	6960.0	3208.2
Эм боох материал		31.9	31.9
Аж ахуйн материал	7689.7	22397.5	14707.8
Сэлбэг хэрэгсэл		1343.2	1343.2
Барилгын засвар		1005.5	1005.5
Түлш, шатах тослох материал	1024.5	783.8	-240.7
Хүнсний материал	2571.5	2263.6	-307.9
Бусад хангамжийн материал	62247.1	37260.3	-24986.8
Бэлэн бүтээгдэхүүн		33.3	33.3
Нөөцийн бараа		10000.0	10000.0
Дүн	79009.9	96746.8	17736.9

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд хандив тусламж 9937.6 мянга, шилжүүлэн авсан 10000.0 мянга, төсвийн хөрөнгөөр 235487.5 мянган төгрөгийн бараа материал авч, 241688.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Хүснэгт №3.1 материалын дэлгэрэнгүй /мянган төгрөг/

№	Байгууллага	Эхний үлдэгдэл	Бараа материал							
			нэмэгдсэн				Бүгд	хасагдсан	Бүгд	Эцсийн үлдэгдэл
			Төсвийн хөрөнгөөр	Хандив тусламжаар	шилжүүлэн авсан	бусад		Худалдан зарцуулсан		
1	ИТХ	820.0	11657.3				11657.3	10240.5	10240.5	2236.8
2	ЗДТГазар	60618.0	57841.0	7162.2		4000.0	69003.2	83952.7	83952.7	45668.5
3	Сургууль	312.8	60406.9	1743.8			62150.7	45137.7	45137.7	17325.8
4	Цэцэрлэг	3222.4	29567.9				29567.9	26573.6	26573.6	6216.7
5	Соёл	822.0	5977.8				5977.8	5320.6	5320.6	1479.2
6	ЭМТөв	13214.7	70036.5	1031.6			71068.1	70463.0	70463.0	13819.8
7	ОНХСан					10000.0	10000.0		0.0	10000.0
	Дүн	79,009.9	235,487.5	9,937.6	10,000.0	4,000.0	259,425.1	241,688.3	241,688.3	96,746.8

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4268791.1 мянга, эцсийн үлдэгдэл 4533079.8 мянган төгрөг болж, 264288.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	3,193,378.5	3,322,062.0	128,683.4
Тээврийн хэрэгсэл	214,404.8	314,904.8	100,500.0
Машин тоног төхөөрөмж	431,801.4	430,178.5	-1,622.9
Тавилга эд хогшил	162,355.0	170,245.6	7,890.6
Дуусаагүй барилга, байгууламж	15,800.0	5,800.0	-10,000.0
Номын фонд	9,714.1	10,332.8	618.7
Бусад үндсэн хөрөнгө	132,931.6	171,150.6	38,219.0
Программ хангамж	1,777.6	1,777.6	0.0
Бусад биет бус хөрөнгө	106,628.0	106,628.0	0.0
Дүн	4,268,791.1	4,533,079.8	264,288.7

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 32146.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй, хандив тусламжаар 345751.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 103609.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан, 10000.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлж оны эцэст 4533079.8 мянган төгрөгийн үндсэн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №4.1 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй /мянган төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Төсвийн болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдаж авсан	Үнэ төлбөргүй хандив, тусламжаар авсан	Шилжүүлэн авсан	Акталсан	Балансаас баланс-д шилжүүлж өгсөн	Эцсийн үлдэгдэл
Сургууль	927,924.77	16,576.30			19,192.14		925,308.93
Цэцэрлэг	120,933.25	1,220.85			4,066.76		118,087.34
Эрүүл мэндийн төв	555,903.15	8,949.60			2,274.20		562,578.56
Соёлын төв	841,237.22	700	27,500.00		10,000.00		859,437.22
ИТХ	88,215.58	2,700.00			4,620.00		86,295.58
ЗДТГ	1,724,577.12	2,000.00	318,251.61		63,456.53		1,981,372.20
ОНХСан	10,000.00					10,000.00	0.00
Дүн	4,268,791.08	32,146.75	345,751.61	0.00	103,609.62	10,000.00	4,533,079.82

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5734.2 мянга, эцсийн үлдэгдэл 122775.0 мянган төгрөг болж, 117040.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	5734.2	122775.0	117040.8
Ажилчидтай холбогдсон өглөг	1378.8	278.1	-1100.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	105.3	22.9	-82.4
Байгууллагад төлөх өглөг	4250.1	122474.0	118223.9
Нийт дүн	5734.2	122775.0	117040.8

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн өглөгийн 99.7 хувийг байгууллагад төлөх өглөг эзэлж байна. Энэ нь орон нутгийн хөгжлийн санд уул уурхайн хүдэр боловсруулах цехийн шаламын орлогоос 194955.7 мянган төгрөг оруулахаар төлөвлөж 65000.0 мянган төгрөг орж 129955.7 мянган төгрөг ороогүй байгаа ба орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг тендер зарлаж гүйцэтгэж хүлээн авсныг тайланд өглөгөөр бүртгэсэнтэй холбоотойгоор 121487.0 мянган төгрөгийн өглөг үүсжээ.

Хүснэгт 5.1 Өглөгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

№	Төсвийн захирагч	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:	
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллага хоорондын
1	Сургууль	133.0	335.7	248.7	87.0
3	Соёлын төв	813.7	14.4	14.4	
4	ИТХ		15.0	15.0	
5	ЗДТГ				
6	Эрүүл мэндийн төв	3887.5			
7	Цэцэрлэг		22.9		22.9
8	ОНХС	900.0	122387.0		122387.0
	Дүн	5734.2	122775.0	278.1	122496.9

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3408024.6 мянга, эцсийн үлдэгдэл 3499656.2 мянган төгрөг болж, 91631.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалж өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	1368520.2	1368520.2		39.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1253710.9	1253710.9		35.8
Хуримтлагдсан үр дүн	785793.5	877425.1	91631.6	25.1
Дүн	3408024.6	3499656.2	91631.6	100

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын капитал данс, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд өөрчлөлт ороогүй ба хуримтлагдсан үр дүн нь тайлант хугацааны үр дүнгээр өссөн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2019 оны төсөв батлах тухай 10/03 дугаар тогтоолд зааснаар Баян-Овоо сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 20700.0 мянга, аймгийн төсөвт мянга, нийт 279200.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 357256.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 119.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого / мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	20,700.0	19,787.4	(912.6)	95.6
1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	16,000.0	14,415.2	(1,584.8)	90.1
1.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар	4,000.0	4,925.9	925.9	123.1
1.3.Агаарын бохирдлын төлбөр	700.0	446.3	(253.7)	63.8
2.Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	279,200.0	337,469.0	58,269.0	120.9
2.1.Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	220,000.0	301,546.0	81,546.0	137.1
2.2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	42,000.0	18,594.4	(23,405.6)	44.3
2.3.Газрын төлбөр	11,000.0	11,094.2	94.2	100.9
2.4.Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	6,200.0	6,234.4	34.4	100.6
Нийт дүн	299,900.0	357256.4	57356.4	119.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хувиар биелүүлж 95.6 хувиар тасарсан нь аж ахуйн нэгжийн орлогын албан тавар 1584,8 мянга, агаарын бохирдлын татвар 253.7 мянган төгрөгөөр дутуу орлого төвлөрсөнтэй холбоотой байна. Аймагт төвлөрүүлэх орлогыг 120.9 хувиар биелүүлж 20.9 хувиар орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2018.12.17-ний өдрийн 09/02 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын орлогыг 62450 мянга, татварын бус орлогыг 14000.0 мянга, ТБӨ-г 840.0 мянга нийт 77290.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 111743.1 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 144.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумын орон нутгийн орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	62,450.0	101,714.5	39,264.5	162.9
1.1.ИОТХ	30,000.0	52,285.1	22,285.1	174.3
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	5,500.0	5,849.0	349.0	106.3
Хөрөнгийн Орлого			0.0	
1.4. Бууны татвар	850.0	860.0	10.0	101.2
1.5.Улсын тэмдэгтийн хураамж	1,500.0	4,022.9	2,522.9	268.2
1.6.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	4,800.0	5,202.5	402.5	108.4
1.7.ТТАМАТөлбөр	300.0	1,050.0	750.0	350.0
1.8 Ан агнуур	19,200.0	32,000.0	12,800.0	166.7
Бусад Татвар			0.0	
1.9 Нохойны татвар	300.0	445.0	145.0	148.3
2.Татварын бус орлого	14,000.0	9,159.1	-4,840.9	65.4
2.1 Хүү торгуулийн орлого	14,000.0	9,159.1	-4,840.9	65.4
ТБӨ	840.0	869.5	29.5	103.5
Нийт дүн	77,290.00	111,743.10	34,453.10	144.6

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1898660.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1622172.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 276488.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 855846.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 27028.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 567457.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 71988.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 89065.8 мянган төгрөгийн оны эхний үлдэгдлээс, 287274,2 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг бүрэн авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 9871.7 мянга дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 85978.5 мянган төгрөг оруулахаас 29794.6 мянган төгрөг оруулж, батлагдсан төсвөөс 56183.9 мянган төгрөгөөр орлого дутуу төвлөрүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлогоор сумын ЗДТГ 840.0 мянган төгрөгөөс 869.5 мянга, Орон нутгийн хөгжлийн сангаас 194955.7 мянган төгрөгөөс 65000.0 мянган төгрөг, сум хөгжүүлэх сан 85978.5 мянган төгрөгөөс 29794.6 мянга, соёлын төв 1000.0 мянган төгрөгөөс гүйцэтгэлээр 399.0 мянга, тус тус төвлөрүүлж нийт гүйцэтгэлээр 186740.6 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого, орон нутгийн хөгжлийн санд орох шаламын орлого дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1695415.3 төгрөг буюу 89.3 хувьтай байгаа нь цалин 3506.5 мянга, хоол хүнс 1229.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 7605.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 56618.3 мянга, үдийн цайны зардал 1826.1 мянга, хөрөнгийн зардал 130364.3 мянган төгрөгөөр тус тус зарцуулагдаагүй гарсан зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Энэ нь сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сангийн орлого дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	64098.9	63727.3	371.6	99.4
Засаг даргын Тамгын газар	282480.8	282387.0	93.8	99.9
Ерөнхий боловсролын сургууль	467581.8	464098.0	3483.8	99.2
Цэцэрлэг	174196.8	172251.1	1945.7	98.9
Соёлын төв	87940.7	87337.8	602.9	99.3
Эрүүл мэндийн төв	375873.2	365675.4	10197.8	97.3
Сум хөгжүүлэх сан	170000.0	113815.0	56185.0	67.0
Орон нутгийн хөгжлийн сан	276488.0	146123.7	130364.3	52.8
Нийт дүн	1898660.2	1695415.3	203244.9	89.3

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсөв: Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 42738.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр олгож бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 22602.0 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 17520.4 мянган төгрөгийг тус тус зарцуулах эрхийг нээж 401222.4 мянган төгрөгийг зарцуулж 2616.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн судалгаа /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1000.0	1000.0
Засаг даргын Тамгын газар	18514.3	18514.3
Эрүүл мэндийн төв	3.7	3.7
Ерөнхий боловсролын сургууль	22520.4	22520.4
Соёлын төв	700.0	700.0
Цэцэрлэг		
Нийт дүн	42738.4	42738.4

Эх сурвалж: Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал
Байхгүй

2.12. Шилэн дансны мэдээлэл

Баян-Овоо сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 85 мэдээллийг хугацаанд нь, 58 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	3	14	8	4	2
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	5	3	
4	Сар бүр	5	60	37	23	
5	Тухай бүр	5	60	32	28	
6	Нийт	18	145	85	58	2

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 1,2,6,11 сарууд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) 1,4 дүгээр улирал, 2,3,6,10,11,12 дугаар сарууд, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) 1,2,6,10,11 дүгээр сарууд, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 1,2,6,11 дүгээр сарууд, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 1,2,6,11 дүгээр сарууд, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) 1-11 дүгээр сарууд, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 1,2,3,6,10,11 дүгээр сарууд, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 1,2,6,7,10,11 дүгээр сарууд, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) 1,2,6,10,11 дүгээр сарууд, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр) 1,2,6,10,11 дүгээр саруудад тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны аудитыг ахлах аудитор Б.Азбаяр хийж байсан ба зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баян-Овоо сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

1. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баян-Овоо сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 267.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 70.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 64.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 132.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Цалингийн зардлаасаа Эрүүл мэндийн төв 1.0 сая төгрөгийн шагнал олгосон,ЗДТГ 5.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,Сум хөгжүүлэх сангаас олгосон 25 зээлдэгчийн 63.9 сая төгрөг хугацаа хэтэрсэн байхад арга хэмжээ авч ажиллаагүй, зэрэг зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон байна. Мөн Эрүүл мэндийн төв урсгал засварын зардлаас ширээ сандал худалдан авсан, ЗДТГ орон тоо батлагдаагүй байхад спортын арга зүйч ажиллуулсан, шатахууны тооцоо бодолгүй шатахуун зарцуулдаг, НБББББ баримт бичиг байхгүй, хандиваар ирсэн автомашин тус байгууллагын эзэмшилд ирээгүй шилжиж ирсэн баримт бичиг байхгүй, өвсний тооцоог бодоогүй, зочид төлөөлөгч хүлээж авах зардлыг зориулалт бусаар зарцуулсан, эрүүл мэндийн төв бараа үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн зэрэг зөрчил илэрч 132.1 сая төгрөгийн зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна. ЗДТГ нь дээрх зөрчлүүдээс шалтгаалан “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан үнэн зөв нэгтгэгдэхгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгө шамшигдуулах.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, Төсвийн тухай хуульд заасан эрхээ бүрэн

хэрэгжүүлж цаашид харьяа байгууллагуудын гаргасан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	267,636,763.37	334,761,519.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	89,404,519.09	36,603,073.35
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	89,404,519.09	36,603,073.35
3121	Төгрөг	89,404,519.09	36,603,073.35
31211	Төрийн сангийн харилцах	89,404,519.09	36,603,073.35
33	АВЛАГА	99,222,322.09	201,411,668.88
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	307,572.09	2,994,518.88
335	Бусад авлага	10,642,000.00	18,499,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,652,000.00	1,609,000.00
